



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй
тогтолцоог бүрдүүлэх нь

ОУХБ-ын сургалтын хөтөлбөр


Модуль

0

- ▶ Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь ОУХБ-ын шинэ сургалтын хөтөлбөрийн танилцуулга

► Модуль 0

Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь ОУХБ-ын шинэ сургалтын хөтөлбөрийн танилцуулга



Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага

Анхны хэвлэл 2010

Хоёр дахь хэвлэл 2022

Олон улсын хөдөлмөрийн товчооны хэвлэл нийтлэл нь Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцын 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрх эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд ОУХБ-ын Хэвлэл нийтлэлийн албанд (Эрх, зөвшөөрөл) ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар, эсвэл rights@ilo.org гэсэн цахим шуудангаар хандана уу.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.ifrro.org хаягаар мэдээлэл авна уу.

Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бий болгох нь ОУХБ-ын сургалтын хөтөлбөр / Олон улсын хөдөлмөрийн байгууллага – Женев хот: ОУХБ, 2021

ISBN: 9789220416815 (хэвлэмэл)

9789220416822 (веб PDF)

Мөн англи хэл дээр, ILO Curriculum on Building Modern and Effective Labour Inspections Systems: introduction to the new ILO curriculum on Building Modern and Effective Labour Inspection Systems ISBN: 9789220361993 (веб PDF) Женев, 2021, франц хэл дээр, Curriculum de l'OIT pour la création de systèmes d'inspection du travail modernes et efficaces, ISBN 9789220362006 (веб PDF); болон Испани хэл дээр, Plan curricular sobre desarrollo de sistemas de inspección del trabajo modernos y eficaces, 9789220362013 (веб pdf), Женев, 2021

НҮБ-ын практикт нийцүүлэн гаргадаг ОУХБ-ын хэвлэл нийтлэлд ашиглагдсан тодорхойлолт, тусгагдсан материалууд нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс аливаа улс орон, бүс, газар нутаг, эрх барих байгууллагын эрх зүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаар тогтоохтой холбоотой ямарваа үзэл бодол илэрхийлээгүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа, бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү зохиогч хүлээх бөгөөд Олон улсын хөдөлмөрийн товчооноос хэвлэн нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг хүлээн зөвшөөрсөн хэрэг биш юм.

Байгууллагуудын болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүний нэр, үйл явцын талаар дурдсан нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой байгууллагын нэр, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь ч тэдгээрийг үгүйсгэсэн асуудал биш болно.

ОУХБ-ын хэвлэл нийтлэл болон цахим бүтээгдэхүүний талаарх мэдээллийг www.ilo.org/publns хаягаар авах боломжтой.

Монгол Улсад хэвлэв. 2024 он.

► Өмнөх үг

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 жилийн ойг тохиолдуулан баталсан Хөдөлмөрийн ирээдүйн тухай ОУХБ-ын зууны тунхагт “Бүх ажиллагчдын эрхийг хамгаалахад хөдөлмөрийн асуудлаар ажилладаг байгууллагуудыг бэхжүүлж, ажиллагсдын эрхийг хамгаалах, тодорхой байдлыг хангахад хөдөлмөрийн харилцаа нэг чухал арга хэрэгсэл болж байгааг улам бүр бататгахын зэрэгцээ тодорхой хэмжээнд албан бус эдийн засаг ажиллаж байгааг хүлээн зөвшөөрөхийн ялдамд албан бус эдийн засгаас албан эдийн засаг руу шилжүүлэхэд үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай байна” гэснийг тухайлан онцолсон. Зууны тунхагт хөдөлмөрийн удирдлага, хөдөлмөрийн хяналтын байгууллагын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байгааг онцгойлон тэмдэглэжээ.

Мөн НҮБ-ын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцэж байгаа бөгөөд ялангуяа Зорилго 8-тай “бүх ажиллагчид, тэдний дотор цагаач ажиллагчид, ялангуяа цагаач эмэгтэйчүүд, баталгаагүй хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн эрхийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг баталгаажуулах” болон Зорилго 16 “тогтвортой хөгжлийн төлөө бүх талын оролцоог хангасан нийгмийг хөгжүүлж, хүн бүхийг хуулиар хамгаалуулах боломжоор хангах, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүх талын оролцоог хангасан институтийг бий болгох” явдал юм. Хөдөлмөрийн хяналт нь ажил олгогч, ажилтанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөдөлмөрийн хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар техникийн зөвлөгөө өгөх замаар Зохистой хөдөлмөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Хөдөлмөрийн хяналт нь үндэсний хэмжээнд хөдөлмөрийн бодлого, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн нэн чухал тогтолцоо юм. Хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 1947 оны 81 дүгээр конвенц болон Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 1969 оны 129 дугаар конвенцууд нь хөдөлмөрийн хяналтын үндэсний хүчирхэг, уян хатан тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн ОУХБ-ын засаглалын дөрвөн конвенцын хоёр нь юм.

ОУХБ-ын Олон Улсын Сургалтын Төв нь бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр хөдөлмөрийн хяналтын байгууллагад дэмжлэг үзүүлэх үндсэн үүргээ гүйцэтгэсээр байна. Улсын хэмжээнд хөдөлмөрийн байцаагч нарыг сургалтад хамруулснаар байцаагчийн чадамж, ур чадварыг хөгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой юм. Үүнд: хөдөлмөрийн захиргааны алба, хөдөлмөрийн хяналтын байгууллага, ажиллагсад болон ажил олгогчдын чадавхыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтын сайн туршлагыг дэлхий даяар солилцохыг дэмжих зэрэг орно.

Энэхүү шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь өмнөх хувилбар болон өнгөрсөн хугацааны туршлага дээр үндэслэн боловсруулсан. Ихэнх улс оронд тулгарч буй бэрхшээл болох ялгаварлан гадуурхалт, гэрийн үйлчилгээний ажил, ажлын байрны дарамт, хүчирхийлэл зэрэг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар шинэ модуль нэмж оруулав.

ОУХБ нь олон улсын хөдөлмөрийн хэм, хэмжээ болон энэхүү шинэчилсэн сургалтын модулиар дамжуулан хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хөдөлмөрийн хяналтын зөв бодлоготой уялдуулах замаар хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бэхжүүлэхийг зорьж байна.

Жаким Пауло Пинтадо Нунес

*Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэлтсийн (LABADMIN/OSH) дарга,
Засаглал ба гурван талт түншлэлийн асуудал хариуцсан хэлтэс
Женев, Швейцар*

Гүсеппе Касале

*ОУХБ-ын Олон улсын сургалтын төвийн захирал
Турин, Итали*

► Талархал

Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлыг Засаглал ба гурван талт түншлэлийн асуудал хариуцсан хэлтсийн Хөдөлмөрийн удирдлага, хөдөлмөрийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Хавьер Барберогийн удирдлага дор Хөдөлмөрийн удирдлага, хөдөлмөрийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн (LABADMIN/OSH)-ын хэлтсийн мэргэжилтнүүдийн баг гүйцэтгэсэн юм.

Хавьер Барберо, Эндрю Кристиан, Арсенио Фернандес, Грейс Халим, Фредерик Лезнэ-Ауэр болон Чанюу Зу гэх мэргэжилтнүүдээс бүрдсэн баг нь модулийг шинэчлэх ажлыг хариуцаж ажиллалаа. Багийн гишүүд шинэ сургалтын хөтөлбөрийн чанар, агуулгыг сайжруулахад анхааран ажиллав.

Энэхүү сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэн, хамтран ажилласан ОУХБ-ын ажлын хамт олон, газар хэлтсийн мэргэжилтнүүд болон зөвлөхөөр ажилласан та бүхэнд багийн гишүүдийн нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

ОУХБ-ын Олон улсын сургалтын төвийн Феликс Мартин-Даза-гийн удирдлага дор Массимилиано Леоне, Паола Биссака нар хэвлэлийн эх бэлтгэл, загварыг харин Ана Буздуган хамтын ажиллагааг хариуцан ажилласанд гүнээ талархаж байна.



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Энэхүү сургалтын хөтөлбөрийг Европын Холбооны санхүүжилтээр “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Монгол хэл рүү орчуулан хэвлэв. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг. Сургалтын хөтөлбөрийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбооны албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү хэвлэлд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо хариуцлага хүлээхгүй болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын чиг үүрэг 2023 оноос салбарын яамандаа шилжин ирж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчид салбарын хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд салбар дундын хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлагдаж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн.

Хөдөлмөрийн тухай хуулиар зохистой хөдөлмөрийн үзэл санааг үндэсний хэмжээнд хангах зорилго, зорилт бүхий зохицуулалтууд хуульчлагдан, хөдөлмөр эрхлэлтийн харилцааны хүрээ өргөжсөнөөр ажил олгогч, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэний хөдөлмөрийн харилцаан дахь зохистой, тэнцвэрт байдал бий болж, тэдний хөдөлмөрлөх суурь эрх хангагдах хууль эрх зүйн орчин бүрдсэн юм.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн чиг үүргийг ОУХБ-ын “Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81 дүгээр конвенцын чиг хандлагад нийцүүлэн холбогдох хэм хэмжээг хуульчилж өгсөн.

Хөдөлмөрийн харилцааны зохистой, тэнцвэрт байдлыг хангаж, хэрэгжүүлэхэд хөдөлмөрийн хяналтын өнөөгийн бүтэц тогтолцоо, чиг үүргийг тодорхой болгох, байцаагчдын хяналт шалгалт хийх арга барилыг өөрчлөх, мэдлэг чадварыг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү хэрэгцээ шаардлагын үндсэн дээр 2024 онд ОУХБ-тай хамтран олон улсад хөдөлмөрийн хяналтын байцаагчдыг бэлтгэдэг “Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь” ОУХБ-ын сургалтын 17 модулийг орчуулж, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг үндэсний хэмжээнд үе шаттайгаар сургах ажлыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж, эхний 30 улсын байцаагчийг энэхүү модуль хөтөлбөрийн хүрээнд сургаад байна.

Монгол Улсад энэхүү сургалтын модуль хөтөлбөрийг нутагшуулснаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагчдыг үе шаттай сургах, улсын байцаагчдын үйл ажиллагааг дэмжих, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн хяналт шалгалт хийх, байцаагчийн ажлын үр дүнг дээшлүүлэх, хяналт шалгалт хийхэд салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, зарчим, арга зүйг эзэмшүүлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

Цаашид энэхүү модуль хөтөлбөрөөр зохион байгуулж буй онол, практик хосолсон сургалтыг Удирдлагын академитай хамтран үе шаттай, тасралтгүй зохион байгуулж, нийт байцаагчдаа бүрэн хамруулж, хяналт шалгалтын нэгдсэн арга зүйтэй болохыг зорьж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчид Та бүхэн энэхүү модуль хөтөлбөрийн хүрээнд олж авсан мэдлэгээ улам бататгаж, Олон Улсын хөдөлмөрийн хяналтын чиг хандлага, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилтэй хөл нийлэн алхсан чадварлаг хамт олон болж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтаа мэдрэмжтэй, хүнлэг, шударга хийж, ажилтан хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгааллыг хангуулахад хөдөлмөр, зүтгэлээ зориулан ажиллана гэдэгт итгэж байна.

▶ Агуулга

▶ Өмнөх үг	I
▶ Талархал	II
▶ 1. Удиртгал	1
▶ 2. Шинэ сургалтын хөтөлбөр	3
▶ 3. Модулийн бүтэц, агуулга	6
▶ 4. Сургалтын стратеги, зорилтот бүлэг	9
▶ 5. Дараагийн алхам	10
5.1 Шинэ модуль боловсруулах	10
5.2 Орчуулга, тохируулга	10
5.3 Сургагч багш бэлтгэх сургалт: Илүү олон хүнд хүрэх нь	10
▶ Хавсралт: Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь сургагч багш бэлтгэх хоёр долоо хоногийн сургалтын жишиг хөтөлбөр	10

► 1. Удиртгал

Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээгээр тодорхойлсон хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, хөдөлмөрлөх эрхийг хэрэгжүүлэхэд хөдөлмөр эрхлэлтийн бодлого, бүхий л үйл явцад нийгмийн түншүүдийг оролцуулсан үр дүнтэй нийгмийн зөвшилцөл, түүнчлэн хөдөө аж ахуйн салбарыг хамарсан үр дүнтэй хөдөлмөрийн хяналтын тогтолцоо шаардлагатай байна.

Шударга даяаршлын төлөөх нийгмийн шударга ёсны тухай ОУХБ-ын тунхаг нь дараах дөрвөн конвенцын ач холбогдлыг засаглалын үүднээс онцолж, сайн засаглалын тэргүүлэх хэм хэмжээ хэмээн тодорхойлсон. ОУХБ-аас дөрвөн конвенцыг гишүүн улс хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрхийг сурталчилж, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой засаглалын конвенцууд гэж тодорхойлсон байдаг. Үүнд:

- Хөдөлмөрийн хяналтын тухай 1947 оны 81 дүгээр конвенц
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 1964 оны 122 дугаар конвенц
- Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай 1969 оны 129 дүгээр конвенц
- Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай конвенц 1976 оны 144 дүгээр конвенц

Эдгээр конвенцын хоёр нь хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн бодлогын хэрэгжилтийг хангадаг хөдөлмөрийн удирдлагын гол багана болох хөдөлмөрийн хяналтын асуудлыг авч үздэг. Хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 81 дүгээр конвенц нь хөдөлмөрийн хяналтын үр ашигтай тогтолцоог бий болгоход чиглэсэн хяналт үнэлгээний талаар хэрэгтэй зааварчилгаа өгдөг. Энэ конвенцын 3 (1) дүгээр зүйлд заасны дагуу хөдөлмөрийн хяналтын тогтолцооны үндсэн чиг үүрэг гэдэгт дараах асуудал хамаарна. Үүнд:

- хөдөлмөрийн нөхцөл, ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж байх үед хамгаалах, тухайлбал ажлын цаг, цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд болон халамжийн үйлчилгээг хангах, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон бусад холбогдох асуудлууд зэрэг хөдөлмөрийн хяналтын байцаагчийн сахиулбал зохих хуулийн заалтыг хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах;
- эдгээр хуулийн заалтыг хэрэгжүүлэх хамгийн үр дүнтэй арга замын тухай техникийн мэдээлэл, зөвлөгөөг холбогдох ажил олгогчид болон ажилтанд хүргэх;
- одоо үйлчилж буй хуулийн заалтад тусгайлан тусгагдаагүй зөрчил дутагдал, зүй бус үйлдлийг эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

Дээр дурдсан чухал үүргүүдийг хөдөлмөрийн байцаагчид илүү сайн гүйцэтгэх боломжийг олгохын тулд холбогдох олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд тэдний сургалтын талаар тодорхой шаардлагыг тогтоодог. Хөдөлмөрийн байцаагчийн чадавхыг бэхжүүлснээр хяналт, шалгалтын чиг үүрэг илүү үр дүнтэй болдог. Тухайлбал: ОУХБ-ын 81 дүгээр конвенцын 7 дугаар зүйлийн 3-т зааснаар *"Хөдөлмөрийн хяналтын байцаагч ажил үүргээ гүйцэтгэхэд зориулсан холбогдох сургалтад хамрагдсан байна."*, ОУХБ-ын 129 дүгээр конвенцын 9 дүгээр

зүйлийн 3-т “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын байцаагч ажил үүргээ гүйцэтгэхийн тулд мэргэжлийн зохих түвшинд бэлтгэгдсэн байх ёстой бөгөөд тэднийг ажиллаж байх хугацаанд нь цаашид холбогдох сургалтад хамруулах талаар арга хэмжээ авна.”, Хөдөлмөрийн удирдлагын тухай ОУХБ-ын 1978 оны конвенцын 10 дугаар зүйл (№150)-д “Хөдөлмөрийн удирдлагын тогтолцооны ажилтнууд нь тэдний томилсон үйл ажиллагаанд тохирсон мэргэшсэн, эдгээр үйл ажиллагаанд шаардлагатай сургалтад хамрагдах боломжтой хүмүүсээс бүрдэнэ, мөн гаднын зохисгүй нөлөөллөөс ангид байна” гэж тус тус заасан байдаг.

Олон улс орнуудад, ялангуяа хөгжиж буй орнуудад хөдөлмөрийн хяналтын байцаагчдыг анхан шатны болон ажлын байран дээрх зохих сургалтад хамруулахад санхүүг болон хүний нөөцийн хувьд дутагдалтай байдаг. Шинээр гарч буй хууль тогтоомж, эрсдэлт хүчин зүйлс болон технологийн шинэчлэлтэй уялдуулан хөдөлмөрийн байцаагчийн мэдлэг, чадамжийг тасралтгүй дээшлүүлэх зорилгоор хөдөлмөрийн хяналтын үндэсний сургалтын бодлого, механизмыг боловсруулах шаардлагатай.

Сургалтын агуулга, арга барил нь төрөл бүрийн ажиллагчдын хэрэгцээ, хөдөлмөрийн байцаагчийн үүрэг хариуцлагад тохирсон байх хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан сургалтын хөтөлбөрийг нь уян хатан боловсруулах боломжтой бөгөөд тухайн байцаагчийн хэрэгцээ шаардлагад тохируулан өөр өөр модулиудыг сонгох, сургалтын төрөл бүрийн хэлбэрийг ашиглаж болохуйц байна.

Эцэст нь хэлэхэд хөдөлмөрийн хяналтын ажил бол мэргэжил юм. Хөдөлмөрийн байцаагчийг сургах асуудал зөвхөн хөдөлмөрийн байцаагчийн албан үүргээ гүйцэтгэх хэрэгцээг хангахаас гадна тэдний мэргэшлийг дээшлүүлэхэд чиглэгдэх ёстой.

Ковид-19 цар тахлын хөдөлмөрийн зах зээлд үзүүлсэн нөлөөллийг харахад хөдөлмөрийн зах зээлийн сайн засаглал, хууль эрх зүйн чанд зохицуулалт нь аливаа хямралыг даван туулахад чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэв. Энэ хүрээнд хөдөлмөрийн хяналтын асуудал нь олон улсын хэмжээнд анхаарлын төвд байгаа бөгөөд ялангуяа ХАБЭМ-ийн асуудал тулгарч буй орнуудад нэн чухал хэвээр байна. Хөдөлмөрийн хяналт, ХАБЭМ-ийн асуудал нэн чухал буй энэ үед гишүүн улс хяналт шалгалтын тогтолцоогоо шинэчлэх, дахин төлөвлөх, бэхжүүлэх шаардлагатай байна. Энэхүү тогтолцоог бэхжүүлэхийн тулд институтын чадавхыг сайжруулах хэрэгтэй юм. ОУХБ болон Олон улсын сургалтын төв (ОУСТ) нь гишүүн орнуудын хөдөлмөрийн хяналтын байцаагчдын чадавхыг хөгжүүлэхэд чиглэсэн сайжруулсан сургалтын хөтөлбөрийг бэлдэж энэхүү сорилтыг даван туулахад нь дэмжлэг үзүүлж байна.

► 2. Шинэ сургалтын хөтөлбөр

Норвеги улсын санхүүжилттэй “Хөдөлмөрийн хяналтын үр дүнг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд ОУХБ-ын ОУСТ нь ОУХБ-ын хөдөлмөрийн удирдлага, хяналтын хэлтэстэй хамтран хөдөлмөрийн хяналтын сургалтын хөтөлбөрийн анхны хувилбарыг 2010 онд боловсруулсан. Анхны хөтөлбөр нь сургалтын модуль гарын авлага дээр суурилсан бөгөөд бодлого, зарчим, стратеги, түүнчлэн хэрэгжүүлэх бодит арга хэрэгслүүдийг багтаасан 12 модультай байсан.

Эхний хоёр модуль нь хөдөлмөрийн хяналтын үйл ажиллагааны ерөнхий чиг үүргийг тодорхойлно. Үүнд хөдөлмөрийн удирдлагын тогтолцооноос эхлээд хөдөлмөрийн хяналтын үндсэн чиг үүрэг, гүйцэтгэх үүрэг хамаарна.

1. Хөдөлмөрийн удирдлагын тогтолцооны тухай

2. Хөдөлмөрийн хяналтын тухай

Дараах гурван модуль нь хөдөлмөрийн хяналтын бодлого, стратегитай холбоотой. Эдгээр модулиуд нь бодлого, шийдвэр гаргагчдад чиглэгдсэн бөгөөд хөдөлмөрийн хяналтын тогтолцооны алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлоход удирдамж болно.

3. Хөдөлмөрийн хяналтын бодлого, төлөвлөлт

4. Хуулийн хэрэгжилтийг дэмжих стратеги боловсруулах

5. Хамтын ажиллагаа ба түншлэл

Дараагийн дөрвөн модулиар хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд гэсэн хөдөлмөрийн хяналтын үндсэн гурван чиглэлийг авч үзнэ. Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр, хүний наймаа, цагаач ажиллагчид, хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсдын асуудалд онцгой анхаарал хандуулсан хүн амын зарим бүлгийн ажиллагсдад чиглэсэн бие даасан модулийг боловсруулсан.

6. Хөдөлмөрийн нөхцөлийн хяналт

7. Хөдөлмөрийн харилцааны хяналт

8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналт

9. Хүн амын зарим бүлгийн хөдөлмөрийн хяналт

Энэхүү модуль нь хөдөлмөрийн хяналтын ажлын гол цөм болох аж ахуйн нэгжид хяналт хэрхэн хийх талаар дэлгэрэнгүй дурдсан болно. Аж ахуйн нэгжид хийх хяналт шалгалтад хэрхэн бэлтгэх, хяналт хийх, тайлан боловсруулах, хяналтын дараа зөвлөмж өгөх, дахин хийх хяналтын талаар дэлгэрэнгүй оруулсан.

10. Хөдөлмөрийн хяналт шалгалт явуулах

Сүүлийн хоёр модуль нь хөдөлмөрийн байцаагчийн гүйцэтгэлийг сайжруулах арга хэрэгслийг танилцуулж, тэдний ур чадварыг бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулсан.

11. Хөдөлмөрийн хяналтын арга хэрэгслүүд

12. Институтийн чадавхыг бэхжүүлэх нь

Дээрх 12 модуль сургалтын хөтөлбөрийг 10 гаруй хэлээр орчуулж, дэлхийн өнцөг булан бүрд хөдөлмөрийн байцаагч бэлтгэхэд ашиглаж байна. Гэсэн хэдий ч олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, улс орнуудын хөдөлмөрийн хяналтын практикт сүүлийн үед гарсан өөрчлөлтүүдийг харгалзан сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, шинэчлэх, шинэ модуль нэмж оруулах цаг хэдийнээ болжээ.

Ялгаварлан гадуурхалтаас ангид байх нь хөдөлмөрийн хүрээний суурь эрх юм. Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн тухай ОУХБ-ын 1998 оны тунхаглал нь бүх гишүүн орнуудыг хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг сурталчилж, хэрэгжүүлэхийг уриалсан.

Ковид-19 цар тахлын үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд сэтгэл зүйн эрсдэл нь шинэ тулгамдсан асуудал болоод байна. Тиймээс эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд ОУХБ нь 2019 онд Дарамт хүчирхийллийг устгах тухай 190 дүгээр конвенц, 2011 онд Гэрийн үйлчилгээний ажилтны тухай 189 дүгээр конвенцыг тус тус баталсан.

Тиймээс шинэ сургалтын хөтөлбөрт дараах дөрвөн модулийг нэмж оруулав.

13. Хөдөлмөрийн хяналт ба ялгаварлан гадуурхалтаас ангид байх

14. Сэтгэл зүйн эрсдэлтэй холбоотой хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх тухай

15. Сэтгэл зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээ

16. Гэрийн үйлчилгээний ажилд хөдөлмөрийн хяналт хийх тухай

Хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 1947 оны 81 дүгээр конвенцын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсны дагуу хөдөлмөрийн хяналтын чиг үүргийг гүйцэтгэхэд зөөлөн ур чадвар ихээхэн ач холбогдолтойг харгалзан хөдөлмөрийн байцаагчдад зориулсан зөөлөн ур чадварын модулийг шинэ сургалтын хөтөлбөрийн төгсгөлд 17 дугаар модуль болгон оруулав.

17. Хөдөлмөрийн байцаагчийн зөөлөн ур чадвар

▶ 3. Модулийн бүтэц, агуулга

Модуль тус бүрийг дор харуулсан бүтцээр боловсруулав.

- ▶ Сэдвийн тухай ерөнхий мэдээлэл
- ▶ Хичээлийн зорилго
- ▶ Агуулга
- ▶ Сэдвийн дэлгэрэнгүй тайлбар, жишээ, сайн туршлага
- ▶ Ганцаарчилсан болон бүлгийн дасгал ажил, судалгаа, хэлэлцүүлэг
- ▶ Сэдвийн дүгнэлт
- ▶ Ном зүй, нэмэлт материал.

1. Хөдөлмөрийн удирдлагын тогтолцооны тухай

Хөдөлмөрийн удирдлагын тухай ОУХБ-ын 1978 оны 150 дугаар конвенц болон Хөдөлмөрийн удирдлагын тухай 1978 оны 159 дүгээр зөвлөмжид тодорхойлсон хөдөлмөрийн удирдлагын тогтолцооны тухай ойлголт, чиг үүргийн агуулгыг багтаасан.

2. Хөдөлмөрийн хяналтын тухай

Модуль 2 нь хөдөлмөрийн хяналтын түүхэн хөгжил, холбогдох ОУХБ-ын конвенцуудад заасан үндсэн зарчим, үүргийг тайлбарлаж, хяналтыг хэрхэн зохион байгуулах талаар өгүүлсэн. Мөн нийгэм, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, сорилт нь хөдөлмөрийн хяналтад хэрхэн нөлөө үзүүлдэг талаар дурдав.

3. Хөдөлмөрийн хяналтын бодлого, төлөвлөлт

Модуль 3 нь хөдөлмөрийн хяналтын гурван чухал сэдвийг хөндсөн. Үүнд: хөдөлмөрийн хяналтын бодлого, түүнд тусгах асуудлууд; үйл ажиллагааны стратеги төлөвлөлт, хяналт, шалгалт; хөдөлмөрийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үнэлгээ.

4. Хуулийн хэрэгжилтийг дэмжих стратеги боловсруулах

Энэхүү модуль нь зарим улс орны сайн туршлага, ОУХБ-ын удирдамж, зарчим дээр үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах стратегийн талаар ойлголтыг багтаасан. Хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах шаардлага, нөхцөл болон шийтгэлийн арга хэмжээний талаар дурдсан.

5. Хамтын ажиллагаа ба түншлэл

Хөдөлмөрийн хяналтын байгууллага үр дүнтэй ажиллахын тулд өргөн цар хүрээтэй хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд ажиллах хэрэгтэй байдаг. Энэхүү модулийн хүрээнд хамтын ажиллагааны төрөл бүрийн түвшний талаар дэлгэрэнгүй суралцах болно. Хамтын ажиллагаа

нь засгийн газрын яамд, хяналтын байгууллагууд, нийгмийн түншүүд болон бусад оролцогч талуудын хооронд явагддаг. Хөдөлмөрийн хяналтын төрөл бүрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд бусад талуудын оролцоо, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг мөн үндэсний хууль тогтоомж, олон улсын зарчмын талаар суралцана.

6. Хөдөлмөрийн нөхцөлийн хяналт

Модулиар хөдөлмөрийн нөхцөлийн хэд хэдэн асуудлыг авч үзэхдээ ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдэд дурдсан хөдөлмөрийн байцаагчийн үүргийн талаар ойлголт өгнө. Модулийн төгсгөлд хөдөлмөрийн байцаагчид хүрэхэд илүү хэцүү хүн амын зарим бүлэгт нөлөөлөхөд тулгардаг сорилт болон тэдгээр сорилтыг практикт хэрхэн даван туулах талаар тусгайлан иш татсан болно.

7. Хөдөлмөрийн харилцааны хяналт

Энэхүү модуль хөдөлмөрийн ертөнцөд тулгарч буй бэрхшээл, чиг хандлага нь хөдөлмөрийн харилцааны хяналтын чиг үүрэгт хэрхэн нөлөөлж байгаа талаар өгүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааны ойлгомжгүй, тодорхойгүй байдал нь тухайн хөдөлмөрийн байцаагч хяналтын чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд сорилт, бэрхшээл болдог.

Энэ модулийг боловсруулахдаа Хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дахь ОУХБ-ын 2006 оны 198 дугаар зөвлөмжид тулгуурлан боловсруулав. Энэхүү зөвлөмжид ОУХБ-ын гишүүн улс орнуудад дээрх асуудлыг хэрхэн цогцоор нь шийдвэрлэх талаар чиглэл өгсөн байдаг.

8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналт

Энэхүү модуль нь олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн (ХАБЭМ) үндсэн ойлголт, зарчмуудын талаар ойлголт өгнө. Энэ модулиар суралцагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхийн ач холбогдол болон ХАБЭМ-ийн ойлголтыг хэрхэн нэмэгдүүлэх талаар суралцана.

9. Хүн амын зарим бүлгийн хөдөлмөрийн хяналт

Энэ модулиар баталгаагүй хөдөлмөр эрхэлж буй, хөдөлмөрийн нөхцөл нь байнга тааруу байдаг хүн амын зарим бүлгийн ажиллагсдын хэрэгцээг шийдвэрлэхэд хөдөлмөрийн хяналтын байгууллагын үүрэг оролцооны тухай суралцана. Түүнчлэн модулийн агуулга нь хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрт өртсөн, цагаач ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсад зэрэг эдгээр хүн амын зарим бүлгийн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад хөдөлмөрийн байцаагчийн үүрэг оролцооны талаар дэлгэрэнгүй дурдсан.

10. Хөдөлмөрийн хяналт шалгалт явуулах

Модуль 10 нь хөдөлмөрийн байцаагч аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийх үеэр анхаарах ёстой гол асуудлын талаар зөвлөмж өгнө. Ялангуяа шинээр томилогдсон байцаагч нарт хэрхэн хяналт шалгалтын ажлаа төлөвлөх, явуулах, дахин хийх хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулах зэрэг хэрэгтэй мэдээллийг багтаасан. Хөдөлмөрийн хяналтын байцаагчийн үр чадвар нэмэгдсэнээр хяналт шалгалт илүү чанартай болж ажлын үр дүн нэмэгдэнэ.

11. Хөдөлмөрийн хяналтын арга хэрэгслүүд

Энэ модулийн хүрээнд хөдөлмөрийн хяналтын байгууллагаас байцаагчдын ажлыг чиглүүлэх, илүү үр дүнтэй болгоход ашигладаг арга хэрэгслийн талаар суралцана. Эдгээр арга хэрэгслүүдийн зорилго, ашиг тусыг дэлгэрэнгүй өгүүлж, зарим практик жишээг модульд хавсаргав.

12. Институтийн чадавхыг бэхжүүлэх нь

Модуль 12 нь үндэсний бодлоготойгоо нийцүүлэн хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бий болгоход институтийн чадавхыг бэхжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, сорилтын талаар ерөнхий ойлголтыг өгнө. Энэ модулийн хүрээнд насанд хүрэгчдэд зориулсан чадамжид суурилсан суралцах арга барилын талаар суралцана.

13. Хөдөлмөрийн хяналт болон ялгаварлан гадуурхалтаас ангид байх

Энэ модуль нь хөдөлмөр эрхлэлт ялгаварлан гадуурхалтаас ангид байх агуулгын хүрээнд Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай ОУХБ-ын 1958 оны 111 дүгээр конвенц болон Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай ОУХБ-ын 1958 оны 111 дүгээр зөвлөмжид тусгасан ойлголтыг багтаасан. Түүнчлэн Тэгш шан хөлс олгох тухай ОУХБ-ын 1951 оны 100 дугаар конвенцод тусгасан жендерийн тэгш байдлын талаар агуулгыг онцлов.

14. Сэтгэл зүйн эрсдэлтэй холбоотой хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх тухай

Энэхүү модулийн зорилго нь ажлын байран дахь сэтгэл зүйн эрсдэлийн тухай ойлголт, сэтгэл зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, энэ чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад хөдөлмөрийн байцаагчийн үүрэг оролцоог тайлбарлахад оршино.

15. Сэтгэлзүйн эрсдэлээс урьдчилсан сэргийлэх хяналтын арга хэмжээ

Модуль 15-ын хүрээнд үндэсний хууль тогтоомжийн онцлог шинж чанар болон хяналт шалгалтын бодлого, стратегийн загварчлалыг харгалзан байцаагчийн хийх урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээний талаар суралцана.

16. Гэрийн үйлчилгээний ажилд хөдөлмөрийн хяналт хийх тухай

Энэхүү модуль нь гэрийн үйлчилгээний ажилд хөдөлмөрийн хяналт хийх явцад тулгардаг гол бэрхшээлүүдийн талаар өгүүлнэ. Гэрийн үйлчилгээний ажлын тухай ОУХБ-ын конвенцын заалт, зөрчлийн хамгийн түгээмэл эрсдэлүүд, тулгарч буй сорилтыг шийдвэрлэх боломжит аргуудыг тоймлон танилцуулна.

17. Хөдөлмөрийн байцаагчийн зөөлөн ур чадвар

Хөдөлмөрийн байцаагч нь ажилтан, ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчид, ажил олгогчдын байгууллага, шүүгч, прокурор болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллахын тулд зөөлөн ур чадвараа хөгжүүлэх шаардлагатай байдаг. Модуль 17-д дурдсан харилцааны чадвар, бусдад нөлөөлөх, ярилцлага хийх, тайлан бичих, асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах, ёс зүйн хэм хэмжээ зэрэг нь хөдөлмөрийн байцаагчид хэрэгтэй зөөлөн ур чадварууд юм.

► 4. Сургалтын стратеги ба зорилтот бүлэг

Шинэ сургалтын хөтөлбөрийн зорилго нь өмнөхтэйгөө ижил хэвээр байна: Хөдөлмөрийн хяналтын байгууллага нь тухайн улсын нөхцөл байдалдаа тохируулан сургалтын тогтолцоогоо бий болгоход энэхүү сургалтын хөтөлбөрийг жишиг болгон хэрэглэхэд оршино.

Сургагч багш бэлтгэх хоёр долоо хоногийн жишиг хөтөлбөрийг боловсруулсан. Жишиг хөтөлбөрийг ашиглан улс орнууд өөрсдийн онцлог, хэрэгцээ шаардлагадаа тулгуурлан хөтөлбөрөө зохиох боломжтой юм. Хавсралтаас жишиг хөтөлбөрийг үзнэ үү: Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь сургагч багш бэлтгэх хоёр долоо хоногийн сургалтын хуваарь.

Хөдөлмөрийн хяналтын модулийг ашиглан сургагч багш бэлтгэх холимог хэлбэрийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах боломжтой юм. Мөн модулийг орчуулж, тохируулга хийх замаар тухайн улс орон өөрийн хэрэгцээндээ тулгуурлан нутагшуулж түгээн дэлгэрүүлэх боломжтой юм.

Модулийн агуулга, бүтэц нь маш уян хатан бөгөөд модулийг санал болгосон дарааллын дагуу хоёр долоо хоногт багтааж сургалт зохион байгуулж болно. Эсвэл зарим модуль, дасгал ажлыг нь хасаад илүү богино хугацаатай буюу 3-5 хоногийн семинар зохион байгуулах ч боломжтой юм. Мөн бодит кейс, дасгал ажил, илүү дэлгэрэнгүй илтгэл зэргээр баяжуулан олон хоногийн сургалт хийж болно. Зарим модулийг зорилго, агуулга, зорилтот бүлэг болон цаг хугацааны байдлаас шалтгаалан тусад нь богино хугацааны арга хэмжээнд ашиглаж болохоос гадна тухайн нөхцөлд тааруулан дэс дарааллыг өөрчлөн багцлах боломжтой.

Ийм уян хатан бүтцээр янз бүрийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт, семинар зохион байгуулж болно. Тухайлбал:

- Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт
- Хөдөлмөрийн хяналтын байгууллагын удирдах албан тушаалтанд
- Хөдөлмөрийн хяналтын ахлах байцаагчдад
- Шинээр ажилд орсон хөдөлмөрийн хяналтын байцаагчдад
- Суралцагчдад
- Сургагч багш нарт гэх мэт.

► 5. Дараагийн алхам

5.1 Шинэ модуль боловсруулах

Сургалтын хөтөлбөрийг сайжруулж, шинэчлэх ажил нь тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Бид шаардлагатай тохиолдолд илүү олон модулийг нэмж агуулгыг нь баяжуулсаар байх болно. Ойрын хугацаанд дараах модулийг нэмж оруулах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн хяналтын компанит ажлыг зохион байгуулах тухай модуль
- Хөдөлмөрийн хяналт ба нийгмийн хамгааллын модуль
- Үйлдвэрлэлийн томоохон ослоос урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бий болгох тухай ОУХБ-ын 174 дүгээр конвенцын агуулгыг багтаасан модуль
- Хямралын нөхцөл байдалд хөдөлмөрийн хяналтын үүргийн тухай модуль

5.2 Орчуулга, тохируулга хийх

Шинэ сургалтын хөтөлбөрийн Англи хэл дээр бичигдсэн хувь нь "олон улсын" сургалтын жишиг хөтөлбөр юм. Тухайн сургалтын материалыг өөрийн улсын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн орчуулан тохируулга хийхээр бол тухайн онцлогт тохирсон эшлэл, жишээг сонгох хэрэгтэй.

2022 онд шинэ сургалтын хөтөлбөрийг франц, испани хэл рүү орчуулах ажлыг эхэлсэн. ОУХБ-аас энэхүү сургалтын материалыг бусад хэл дээр орчуулж, түгээн дэлгэрүүлэх ажлыг дэмжин ажиллана.

Шинэ сургалтын хөтөлбөрийг цахим хэлбэрээр нийтэлснээр зайнаас суралцахад илүү хүртээмжтэй болсон. Сургалтын материалыг байршуулсан цахим хуудсанд нэмэлт материал, дасгал ажил, үнэлгээний асуулга зэргийг оруулсан.

5.3 Сургагч багш бэлтгэх сургалт: Илүү олон хүнд хүрэх нь


Энэхүү сургалтын материалыг тухайн хэрэгцээ шаардлагадаа тулгуурлан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулахад аль болох хялбар байхад анхааран боловсрууллаа. Гэсэн хэдий ч сургалтын агуулга, арга зүйгээ бүрэн эзэмшсэн чадварлаг багштай байхын тулд сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах нь чухал ач холбогдолтой юм. Тиймээс Италийн Турин хотод ОУХБ-ын Олон улсын сургалтын төвөөс (ITCILO) хөдөлмөрийн хяналтын чиглэлээр ажилладаг удирдах албан тушаалтан, менежер, сургагч багш нарт зориулсан олон улсын сургалтыг зохион байгуулдаг. Сургалтыг илүү хүртээмжтэй болгохын тулд тухайн сургалтад хамрагдсан сургагч багш нарт гарын авлага, танилцуулга, сургалтын хөтөлбөрийн цахим багцыг өгдөг.

► **Хавсралт: Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь сургагч багш бэлтгэх хоёр долоо хоногийн жишиг сургалтын хуваарь**

Цаг/Өдөр	I өдөр	II өдөр	III өдөр	IV өдөр	V өдөр
9.00 – 10.30	ОУХБ болон танилцуулга хичээл	Илтгэл: Хөдөлмөрийн хяналтын бодлого, төлөвлөлт	Илтгэл: Хөдөлмөрийн нөхцөлийн хяналт	Илтгэл & Дасгал ажил: Хүн амын зарим бүлгийн хөдөлмөрийн хяналт Хүүхдийн хөдөлмөрийг устгах Албадан хөдөлмөрийг устгах	Илтгэл: Хяналт шалгалт явуулах
10.30 – 11.00	Цайны завсарлага				
11.00 – 12.30	Илтгэл & Дасгал ажил: Хөдөлмөрийн удирдлагын тогтолцоо	Дасгал ажил: Хөдөлмөрийн хяналтын бодлого, төлөвлөлт	Дасгал ажил: Хөдөлмөрийн нөхцөлийн хяналт	Илтгэл & Дасгал ажил: Хүн амын зарим бүлгийн хөдөлмөрийн хяналт Цагаач болон хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсад	Илтгэл & Дасгал ажил: Хяналт шалгалт явуулах
12.30 – 13.30	Завсарлага				
13.30 – 15.00	Илтгэл: Хөдөлмөрийн хяналтын тухай	Илтгэл: Хуулийн хэрэгжилтийг дэмжих стратеги боловсруулах	Илтгэл & Дасгал ажил: Хөдөлмөрийн харилцааны хяналт	Илтгэл: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд	Илтгэл & Дасгал ажил: Хяналт шалгалт явуулах
13.30 – 15.00	Цайны завсарлага				
15.30 – 17.00	Дасгал ажил: Хөдөлмөрийн хяналтын тухай	Дасгал ажил: Хуулийн хэрэгжилтийг дэмжих стратеги боловсруулах	Илтгэл & Дасгал ажил: Хамтын ажиллагаа ба түншлэл	Дасгал ажил: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд	Илтгэл & Дасгал ажил: Хяналт шалгалт явуулах

► Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь сургагч багш бэлтгэх хоёр долоо хоногийн сургалтын хөтөлбөр

Цаг/Өдөр	VI өдөр	VII өдөр	VIII өдөр	IX өдөр	X өдөр
9.00 – 10.30	Илтгэл & Дасгал ажил: Хөдөлмөрийн хяналт ба ялгаварлан гадуурхалтаас ангид байх	Илтгэл: Сэтгэл зүйн эрсдэлтэй холбоотой хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх тухай	Суралцах гэж юу вэ? Бид хэрхэн суралцдаг вэ? Сургалтын үе шатууд	Сургалтын дизайн (үргэлжлэл) Мэдлэгээ хуваалцах арга замууд (дасгал ажил) Илтгэл бэлтгэх аргачлалын талаар товч мэдээлэл	Бүлгийн хичээл заах
10.30 – 11.00	Цайны завсарлага				
11.00 – 12.30	Илтгэл & Дасгал ажил: Гэрийн үйлчилгээний ажилд хөдөлмөрийн хяналт хийх тухай	Дасгал ажил: Хөдөлмөрийн байцаагч ба сэтгэл зүйн эрсдэл Ажлын байрны стресс	Дасгал ажил: Оролцоон дээр тулгуурлан заах арга барил Лекцийн арга барилаас оролцоонд тулгуурласан насанд хүрэгчдийг сургах арга арга барил руу шилжих нь	Оролцоон дээр тулгуурлан сургалт явуулах Суралцагсдыг идэвхжүүлэх, мэдлэгээ хуваалцах арга техникийг ашиглах	Бүлгийн хичээл заах
12.30 – 13.30	Завсарлага				
13.30 – 15.00	Илтгэл & Дасгал ажил Хөдөлмөрийн байцаагчийн зөөлөн ур чадвар Харилцааны ур чадвар Бусдад нөлөөлөх чадвар Ярилцлага хийх чадвар	Илтгэл & Дасгал: Хөдөлмөрийн байцаагч ба сэтгэл зүйн эрсдэл Ажлын байран дахь хүчирхийлэл	Суралтын хэв маяг, дизайн Сургалтын хэв маяг: өөрийгөө үнэлэх дасгал ажил Зорилгот бүлгийн онцлог шинж чанарууд Суралцах хэрэгцээг үнэлэх нь	Оролцоонд суурилсан сургалтын арга барил Сургалтыг чиглүүлэх 100 зөвлөгөө Суралцах чадварыг үнэлэх Сургалтаа үнэлэх	Бүлгийн хичээл заах
13.30 – 15.00	Цайны завсарлага				
15.30 – 17.00	Илтгэл & Дасгал ажил Хөдөлмөрийн байцаагчийн зөөлөн ур чадвар Асуудал шийдвэрлэх Тайлан бичих Шийдвэр гаргах	Илтгэл & Дасгалууд Хөдөлмөрийн байцаагчийн зөөлөн ур чадвар Ёс зүй Илтгэл хэлэлцүүлэг: Институтийн чадавхыг бэхжүүлэх	Суралтын хэв маяг, дизайн Сургалтын агуулга ба сэдвийн уялдаа холбоо: зорилгоо тодорхойлох, агуулгаа сонгох	Сургалтын арга барилыг хэрэгжүүлэх нь Сургалтын арга барилыг үнэлэх Бүлгийн хичээл хэрхэн зохион байгуулах вэ?	Бүлгийн хичээл заах Сургалтын хаалт



▶ Олон улсын хөдөлмөрийн байгууллага
Засаглал, гурван талт түншлэлийн асуудал хариуцсан хэлтэс
(GOVERNANCE)

Хөдөлмөрийн удирдлага, хяналт, аюулгүй
байдал, эрүүл мэндийн хэлтэс
(LABADMIN/OSH)

4 Route des Morillons 4 CH-1211 Женев 22 Швейцар
Т: +41 22 799 6715
E: labadmin-osh@ilo.org
www.ilo.org/labadmin-osh

📍 НҮБ-ын байр, 604 тоот
Нэгдсэн үндэстний гудамж-12
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201, Монгол Улс

☎ +976 11-320624

✉ ulaanbaatar@ilo.org

🌐 www.ilo.org/mongolia

🌐 Олон улсын хөдөлмөрийн байгууллага
-International Labour Organization

🐦 @ilo_mongolia